



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 5/144

Улаанбаатар хот

Б.Цэрмаад цалинтай чөлөө,  
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.16, 7.3.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын Диспетчерийн албаны Тээвэр зохицуулагч Батмөнхийн Цэрмаагийн бичгээр гаргасан өргөдөл, ар гэрийн гачигдлыг харгалзан үзэж, 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 20-ны өдрийг хүртэл ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Б.Цэрмаад буцалтгүй тусламжид шаардагдах 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Б.Цэрмаагийн албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Диспетчерийн алба /Ц.Мягмар/-нд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /М.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР